

20. Эзэн минь, Уругвайн багт “Найдвар доторх Эмэгтэйчүүд” хөтөлбөрийн зохиолыг бичиж байхад нь мэргэн ухаан, бүтээлч байдал, удирдамжийг өгөөч. (Гал. 5:25).

21. Аав аа, бид гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүд, гэр бүлүүдэд зориулж Бразилд Христэд итгэгчдийг хамгаалах байр олноор байгаасай гэж залбирч байна. Эдгээр нь Есүстэй танилцах аюулгүй газар байг. (Дуу. 27:5)

22. Бурхан минь, АНУ-ын бүсийн багт Есүст итгэх итгэл найдвар бүхий хойч үеийн эмэгтэйчүүдэд хүрч үйлчлэхийн тулд тэдэнд мэргэн ухаан, бүтээлч сэтгэлгээг өгөөч. (Дуу. 78:4)

23. Эзэн минь, Латин Америк болон Карибын тэнгисийн орнуудад бурханлаг эмэгтэйчүүдийг өсгөж, TWR-н “Найдвар доторх Эмэгтэйчүүд” үйлчлэлийг удирдах ирээдүйн сүнслэг удирдагчид бэлтгэгдэх болтугай. (Матай 9:37)

24. Хүндэт Аав аа, Бонайр дахь TWR-н “Найдвар доторх Эмэгтэйчүүд” баг эргэн тойрныхоо эмэгтэйчүүдэд сайн мэдээ тарааж, урам зориг өгөхдөө таны Сүнсээр дүүрэн байх болтугай. (1 Тесалоник 5:11).

25. Бурхан, Венесуэлд эдийн засгийн найдваргүй байдал нүүрлэж байгаа тул тэнд байгаа эмэгтэйчүүдэд төсвөө зохицуулах, гэр бүлдээ хоол хүнс худалдаж авах боломжийг олгооч. (Дуу. 32:8)

26. Эзэн минь, таны мэргэн ухаан, тэвчээр, хайр, үйлчлэлээр өсөж, таны гарт хэрэгтэй хэрэгсэл болох нь Парагвайн багийн зүрхнийхэн хүсэл билээ. (Ром. 12:11)

27. Бурхан минь, залбирлын хуанлийг ашиглан өдөр бүр залбирдаг Канад дахь үнэнч хүмүүсийн төлөө бид таныг магтъя. (Кол. 4:2)

28. Аав аа, Бразилд улс төрийн хагарал, зөрчилдөөнтэй үед Христийн дотор нэгдээсэй гэж бид залбирч байна. Таны хүү бидний зүрх сэтгэлд эвлэрүүлэн, зуучлагч нь байх болтугай. (Матай 5:9)

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송

최초 입금 후 사무실로 연락 주시기 바랍니다

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 65,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



2023.2. Хойд болон Өмнөд Америкийн төлөөх залбирал

“Юунд ч бүү санаа зов. Харин аливаа зүйлд залбирлаараа болон гуйлтаараа талархалтайгаар хүсэлтээ Бурханд мэдүүл”/Фил 4:6/. Бидний амьдрал ямар ч байсан, мөн ямар ч нөхцөлд байсан Бурхан уруу очих урилга юм. Энэ урилгын хариулт бол бидний залбирал. Бурханд болон Түүний хүч чадал, сайн сайханд итгэх итгэлийг батлах явдал юм.

TWR Korea 북방선교방송

서울특별시 관악구 양녕로 15, 월드빌딩 6층
전화 (02)886-5671 / 이메일 phkorea@twr.or.kr

1. Төгс Хүчит Бурхан минь, Бонайр дахь TWR-н “Найдвар доторх Эмэгтэйчүүд” яамны үйлчлэлийг өсгөж, хөгжүүлж өгөөч. Багийнханд үүрэг даалгавраа гүйцэтгэх, хүмүүсийг Есүс рүү хөтлөх, үйлчлэлийн алхам бүрд Та мэргэн ухааныг өгөөрэй. (Дуу. 37:5)

2. Аав аа, ганцаардаж, сэтгэл санаагаар унасан Уругвайн ахмад настнуудыг тайвшруулаач. Тэдэнд урам зориг, дэмжлэг өгөхийн тулд хүүхдүүдээ явуулаарай. (Дуу. 71:9, 18).

3. Эзэн минь, Бразилын удирдагчид эмчилгээ хийлгэх шаардлагатай эмэгтэйчүүдэд маш сайн эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нөхцөл, боломжоор хангаасай гэж бид залбирч байна. (1 Тим. 2:1–2)

4. Парагвайн шоронд байгаа хагас эрх чөлөөтэй эмэгтэйчүүдийг Библи судлах, хичээллэх зорилгоор TWR-н “Найдвар доторх Эмэгтэйчүүд”-н оффис дээр ирэхийг зөвшөөрсөнд Бурхан, танд баярлалаа. (Дуу. 90:17)

5. Эзэн минь, 2023 оноос эхэлж буй Канадын TWR яамны шинэ түншлэлд мэргэн ухааныг өгөөч. Тэд дэлхий даяарх эмэгтэйчүүдийн амьдралын тухай ярьж, Таныг таньж мэдэхэд нь илүү үр дүнтэй байх болтугай. (Исаиа 52:7).

6. “Найдвар доторх Эмэгтэйчүүд” хөтөлбөрөөр дамжуулан Уругвайн эмэгтэйчүүд мэдээлэл, урам зориг, авралыг олж авч байгаад Бурхан танд баярлалаа. (Иохан 3:16)

7. Эзэн минь, АНУ-ын бүс нутгийн үйлчлэлийн багийнхан хамгийн түрүүнд Таны хайр, дуулгавартай байдлыг эрэлхийлэх болтугай. Тэднийг үүргээ гүйцэтгэж байх үед нь та удирдаж, үйлчлэлийн алхам бүрийг нь ерөөж, чиглүүлж өгөөч. (Ром. 12:2)

8. Аав аа, Латин Америкт гэр бүлээ авч явах гэж өдөр бүр тэмцэж буй өрх толгойлсон эхчүүдэд хүч чадал, урам зоригийг өгөөч, мөн сайн ажлын байраар хангаач. (Жиш. 15:2)

9. Хүндэт Эзэн минь ээ, манай Бразил эмэгтэйчүүд Танаар өлсөж цангаж байгаасай гэж бид залбирч байна. Тэд таныг улам илүү эрэн хайж, танруу хандан залбирах болтугай. (Дуу. 42:1–2)

10. Эзэн минь, Парагвай дахь манай багт шинэ технологи ашиглан залбирлын хуанлийг өргөжүүлэх боломжийг олгооч. Залбирлын хуанлийг зуучлалын залбиралдлаа өдөр бүр ашигладаг Испани, Германы залбирлын бүлгүүдэд баярлалаа. (1 Тес. 5:16–18)

11. Аав аа, Уругвайд сайн сайхан ирээдүй хайж ирсэн олон мянган цагаач ажилчид хэрэгцээгээ хангахын тулд танд хандаасай гэж бид залбирч байна. (Филиппой 4:19)

12. Төгс Хүчит Бурхан минь ээ, Гватемалын охид, эмэгтэйчүүд Таныг таньж, Танаас өөрийн мөн чанараа олж, ямар их хайрлаж, өршөөж, үнэлдэг гэдгээ мэдэх болтугай. (Гал. 3:26–28).

13. Тэнгэрлэг Эцэг минь ээ, Бонайрийн ядарсан эмэгтэй хүн бүрд хүч чадал өгөхийг бид танаас гуйж байна. (Исаиа 40:29).

14. Аав аа, Уругвай дахь хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, хүүхдүүдийг хамгаалж, эдгээгээч. Тэднийг хохироосон хүмүүсийн зүрх сэтгэлийг өөрчлөөч. (Дуу. 28:6)

15. Аав аа, бид Аргентин дахь өсвөр үеийн эмэгтэйчүүдийг Есүстэй ойр дотно, утга учиртай алхаж, амьдраасай гэж залбирч байна. Сайн мэдээг тэдэнд хүргэхийн төлөө та хүмүүсээ ашиглаарай. (Иохан 10:10)

16. Их Эзэн минь, "Итгэл найдвартай учрал" номыг Бразил дахь олон эмэгтэйчүүд бүлгийн уулзалтдаа ашиглаж байгаад бид таныг магтъя. Илүү олон сүм үүнийг ашиглах болтугай. (Дуу. 119:105)

17. Бурхан минь, Парагвай дахь манай баг шинэ эмэгтэйчүүдийн элсэлтийн тоог 25 хувиар нэмэгдүүлж, тэдэнд сайн мэдээг хүргэж чадсанд бид таныг магтъя. (1 Иохан 5:4)

18. Уругвайд хар тамхи хэрэглэж, зарж борлуулдаг залуу эмэгтэйчүүдийг нүгэл, гэмт хэргийн сүйрлээс чөлөөлөөч, Эзэн минь. (Дуу. 68:20)

19. Аав аа, Парагвай дахь TWR-н “Найдвар доторх Эмэгтэйчүүд” баг шоронгийн дараах үйлчлэлд болон түүнээс хойших үйл ажиллагаанд ухаалаг, хайраар дүүрэн эмэгтэйчүүдээс бүрдсэн багийг бүрдүүлээсэй гэж бид залбирч байна. (1 Коринт 3:9)